Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Захирагчийн алба нь тосгоны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь "Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуулыг мөрдлөг болгож авлига, ашиг сонирхолын зөрчилд автахгүй үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж, мөрдөн, дотоод ажлыг сайжруулна" гэсэн зорилго дэвшүүлэн энэхүү зорилгыг биелүүлэх хүрээнд дараах зорилт дэвшүүлэн ажилласан байна. Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүнд: 1.Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдалыг хангана.  
2.Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдалыг хангаж ажиллана

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд өөрчлөлт орсон.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн СХШ/46 тоот удирдамжаар Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2022, 2023 оны касс, харилцах, аж ахуйн баримт, хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, тайлан баланс, мэдээ судалгаа болон бусад баримтуудад шалгалт хийгдсэн байна.Уг шалгалтаар 83 литр буюу 0.23 сая төгрөгийн шатахууныг зүй бус зарцуулсан зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны захирагчийн алба нь 2021 оны 12 сарын 27-ны өдрийн А/71 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цагааннуур тосгоны захирагчийн алба 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 299 дүгээр тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72.2 сая төгрөгөөр буюу 17.43 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	7,137.8	7,137.8	-
Үндсэн хөрөнгө	406,930.7	479,130.0	72,199.3
<b><u>Нийт хөрөнгө</u></b>	<b>414,068.6</b>	<b>486,267.9</b>	<b>72,199.3</b>
Өр төлбөр	1,174.4	5,377.7	4,203.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	412,894.1	480,890.2	67,996.1
<b><u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u></b>	<b>414,068.6</b>	<b>486,267.9</b>	<b>72,199.3</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгө, авлагын дансууд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд 40.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 40.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж оны эцэст 7.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 486.3 сая төгрөг болж 72.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлт орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой. Аймгийн Иргэдийн төлөөлөгчидийн хурлаас үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарсаныг үндэслэн 37.5 сая төгрөгний хөрөнгийг акталсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 68.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 404.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 77.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 520.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 668.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 566.1 сая төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгөөс 4.0 сая төгрөг, нийт 570.1 сая төгрөгний санхүүжилтийг үндсэн дансаар хүлээн авч зарцуулан, төсвийн гүйцэтгэлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 570.1 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлтээр Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2.9 сая төгрөгний санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.4 сая төгрөгийн орлого оруулсан байна. Үүнээс 5.3 сая төгрөгөөс гэрээт ажилтны цалинд 0.1 сая, гэрэл цахилгаанд 1.7 сая, түлш хаалалтанд 0.4 сая, тээвэр шатахуунд 0.3 сая, бара үйлчилгээний бусад зардалд 2.6 сая төгрөгийг 100 хувь зарцуулсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80801	Үндсэн үйл ажиллагааны орлого	655,589.8	557,876.6	97,713.2	85.09%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	4,000.0	4,000.0	-	100.00%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	13,868.4	13,617.3	251.0	98.18%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	300.0	-	-	0%
	<b>Дүн</b>	<b>673,758.2</b>	<b>575,493.9</b>	98,264.3	85.41%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй, Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Захирагчийн алба нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 50.0 сая төгрөгөөр баталсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд үндсэн орон тоо 14 батлагдсан ба орон тооны хязгаараас нэг орон тоо илүү ажилуулсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2.9 сая төгрөгний санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.4 сая төгрөгийн орлого оруулсанаар нийт 5.3 сая төгрөгөөс гэрээт ажилтаны цалинд 0.1 сая, гэрэл цахилгаанд 1.7 сая, түлш хаалалтанд 0.4 сая, тээвэр шатахуунд 0.3 сая төгрөгийг, бара үйлчилгээний бусад зардалд 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Цагааннуур тосгоны захирагчийн алба нь батлагдсан төсвийн хүрээнд 40.3 сая төгрөгийн бараа материал, 9.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны Захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ш.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Цагааннуур тосгоны захирагчийн албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 381.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 622.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон болно.

Цагааннуур тосгоны захирагчийн албаны нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2024 онд завсарын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар дараах 1 төрлийн зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийн хангаж хариу ирүүлсэн ба уг зөрчилийг гаргаагүй байна..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	5,900.0	1	5,900.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5,900.0</b>	<b>1</b>	<b>5,900.0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 306.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 306.6 сая төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Санхүү байдлын тайланд эхний үлдэгдэлийг 0.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэлийг 17.4 сая төгрөгөөр илүү гаргасныг залруулав.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны үр дүнг эхний үлдэгдэлд 0.3 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэлийг 17.4 сая төгрөгөөр илүү гаргасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд нийт зарлагыг 9.6 сая төгрөгөөр илүү гаргасныг залруулав.
- Өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капиталын эхний үлдэгдэлийг 44.3 сая төгрөг, хуримтлагдсан үр дүнг 44.3 сая төгрөгөөр илүү тусгасан, эцсийн үлдэгдэл дээр Засгийн газрын оруулсан капиталын дүнг 86.5 сая төгрөг, хуримтлагдсан үр дүнг 69.1 сая төгрөг, Засгийн хувь оролцооны нийт дүнг 17.4 сая төгрөгөөр илүү гаргасныг залруулав.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-ийн 4.1.3, 5 дугаар зүйл 5.1-ийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Сангийн сайдын 2023 оны А/229 тоот тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", УСНББОУС-1 толилуулга стандарттай нийцээгүй байна.

## 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн зөрчилд<sup>1</sup> төлбөрийн 1 акт тогтоов.

1.Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор Цагааннуур тосгоны захирагчийн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Б/06 дугаар захирамжаар 2 албан хаагчид олгосон нийт 12.8 сая төгрөгний таван жилийн мөнгөн урамшууллаас 1.3 сая төгрөгний хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна.

*Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.” Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна*

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 12.3 сая төгрөгийн зөрчилд<sup>2</sup> 1 албан шаардлага хүргүүлэв.

1.Жолоочын шатахууны зарцуулалтын тооцоог зохих журмын дагуу хийгээгүй, замын хуудасгүй, шатахууны талонгүй 12.3 сая төгрөгийн бензин зарцуулсан, шатахууны зарцуулалтыг нормын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Жишиг норм батлах тухай” журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн замын хуудсыг үнэн зөв хөтөлж, шатахууны зарцуулалтын тооцоог Зам тээвэр хөгжлийн сайдын 390 дугаар тушаалын "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлалын дагуу тооцож олгох, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар нийт 175.9 сая төгрөгийн зөрчил<sup>3</sup> илэрч, 175.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Батлагдсан орон тоотой холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 12 өдрийн А/845 дугаартай захирамжаар баталсан орон тооноос үндсэн ажилтан 1 орон, гэрээт ажилтан 3 тоог илүү ажилуулж төсвөөс 46,9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Захирагчийн ажлын албаны батлагдсан орон тооны дагуу бүтэц орон тоог батлаж мөрдөж ажиллах.

#### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

##### 2.1 Илрүүлэлт:

Тайлант онд үндсэн хөрөнгийн бүртгэлээс холбогдох газрын шийдвэрээр 37.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан боловч устгалт хийгээгүй, жилийн эцсийн тооллого хийхдээ 10.4 сая төгрөгний хөрөнгө дутагдсан гэж тэмдэглэсэн боловч эцэслэн шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", 31.3.3-т "засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 8 дугаар зүйлийн 8.3-т "8.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана."

##### 2.1. Өгсөн зөвлөмж:

<sup>3</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Актлах шийдвэрийн дагуу бүртгэлээс хассан 37.5 сая төгрөгийн хөрөнгөнөөс ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлгээ хийж бүртгэлд авах, устгалтын актын баримтжуулах, жилийн эцсийн тооллогын үнэн зөв хийх, тооллогын дүнгээр үлдэгдэлийг тулган баталгаажуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

### **3.Цалин тогтоолттой холбоотой асуудал**

#### **3.1.Илрүүлэлт:**

Захирагчийн 2024 оны 04 сарын 08-ны өдрийн Б/03 дугаартай захирамжаар ажилтнуудын цалинг шинэчлэн тогтооход ажлын албаны даргын цалинг Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнээс буруу буюу ТЗ-6-гаар тогтоож 5.0 сая төгрөгний цалинг илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ад Тосгоны захирагчийн ажлын албаны дарга төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн ТЗ-8-д байхаар заасныг зөрчсөн байна.

#### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Захирагчийн албаны ажлын албаны даргын цалинг Засгийн газрын 487 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн ТЗ-8-аар тогтоож зөрчлийг арилгах;

### **4.Ээлжийн амралтын тооцоотой холбоотой асуудал**

#### **4.1.Илрүүлэлт:**

Ажилтнуудад 2024 оны ээлжийн амралт олгох тушаал гаргаагүй, ээлжийн амралтыг зохих журмаар олгоогүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.4, 99 дүгээр зүйлийн 99.1, 99.2, 99.8, 110 дугаар зүйлийн 110.1, заалтууд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын 1.2, 3.2 заалттай нийцэхгүй байна.

#### **4.2. Өгсөн зөвлөмж:**

Захирагчийн албаны ажилтнуудын ээлжийн амралтын тушаалыг хууль журмын дагуу гаргаж, ээлжийн амралтын мөнгийг тухай бүрт бодож олгож байх;

### **5.Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

#### **5.1.Илрүүлэлт:**

Захирагчийн алба нь эм боох, бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн, аж ахуйн, түлш шатах тослох, сэлбэг хэрэгсэл, барилгын засварын материал, хүнсний материал, бусад хангамжийн материал 40,309.0 мянган төгрөгийн орлого, 49,308.9 мянган төгрөгийн зарлагын нярвын бараа материалын тайланг хөтлөөгүй, жилийн эцсийн бараа материалын 7,137.9 мянган төгрөгний үлдэгдэлийн тооллого хийгээгүй, ашиглах боломжгүй болсон 1,076.1 мянган төгрөгний барааг холбогдох шийдвэр гаргаж актаалгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2- “хөрөнгө, төлбөр тооцооны

тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

## 5.2. Өгсөн зөвлөмж:

Нярвын бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаж тооцоо хийх, олон жил болсон ашиглах боломжгүй болсон бараа материалыг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулж актлах;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг буруу гаргасан	10	306,600.0			10	306,600.0	10	306,600.0				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>306,600.0</b>			<b>10</b>	<b>306,600.0</b>	<b>10</b>	<b>306,600.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	4	58,030.5	1	1,281.7	-	-	3	56,748.8				
Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой	1	47,920.2	-	-	-	-	1	47,920.2				
Шатахууны зардалтай холбоотой	1	12,332.9	-	-	1	12,332.9	-					
Бараа материалын бүртгэлтэй холбоотой	1	57,522.9	0	-	-	-	1	57,522.9				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>175,806.5</b>	<b>1</b>	<b>1,281.7</b>	<b>1</b>	<b>12,332.9</b>	<b>5</b>	<b>162,191.9</b>				